БАТЛАВ

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН

ГАЗРЫН ДАРГА Ц.АМАРТӨГС

2026 оны 01 дүгаар сарын 19

“УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ СААРУУЛАХ, ДАСАН ЗОХИЦОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАН, ХЭРЭГЖҮҮЛЭХ, СУРГАЛТ, ЗӨВЛӨГӨӨН ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

2026 оны 01 дүгээр сарын 19 Даланзадгад

1	Үндэслэл:	- Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын Суурь конвенцын Парисын хэлэлцээрийг Монгол Улс 2016 онд соёрхон батлсан. Тус хэлэлцээрийн дагуу 2020 онд Монгол Улс хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний зорилтоо тодорхойлон, хэрэгжүүлэх үүрэг хүлээснээр БОАЖ-ын сайдын 2021 оны 01/21 дүгээр тогтоолоор батлагдсан “Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө” - Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 407 дугаар тогтоол, - “Алсын хараа -2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 6.4 дэх хэсэг, - Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Өсөлттэй Өмнөговь” хөтөлбөрийн дөрөв дэх бодлого “Хүрээлэн буй орчин, усны нөөцийн бодлого”-ыг тус тус хэрэгжүүлэх. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл нь байгалийн нөөцийн доройтол, цөлжилт, ус, байгалийн гамшигт үзэгдлийн давтамж ихсэх зэргээр илэрч байна. Иймд Өмнөговь аймгийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийг тодорхойлох, хүлэмжийн хийн ялгаралтыг тооцоолох, улмаар уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох арга хэмжээг тодорхойлох шаардлагатай байна.
2	Зорилго:	Өмнөговь аймгийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, өртөмтгий байдал, эрсдэлийг үнэлэх, хүлэмжийн хийн ялгаралтыг тооцоолох, улмаар уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох арга хэмжээг тодорхойлж, “Өмнөговь аймгийн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үйл ажиллагааны төлөвлөгөө”-г холбогдох бодлогын баримт бичиг, хууль журмын хүрээнд боловсруулах.
3	Хамрах хүрээ	Өмнөговь аймгийн хэмжээнд
4	Хамтран ажиллах, зөвшилцөх байгууллага:	-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал -Аймгийн Засаг даргын Тамгын газар -Аймгийн Байгаль орчны газар -Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар -Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар -Аймгийн Онцгой байдлын газар -Аймгийн Эрүүл мэндийн газар -Аймгийн Статистикийн хэлтэс -Аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв -Эрчим хүчний зохицуулах салбар зөвлөл -Сумдын Засаг даргын Тамгын газар -Даян Дэлхийн Ногоон Хөгжлийн Институт
5	Гүйцэтгэх ажил:	1. Өмнөговь аймгийн олон талын оролцоот “Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ” -г байгалийн нөөц (ус, ой, хөрс, биологийн олон янз байдал), нийгэм-эдийн засгийн (дэд бүтэц, барилга, зам тээвэр

		байгалийн гамшиг, нийгмийн эрүүл мэнд, иргэдийн амьжиргаа орлого, хөдөө аж ахуй) салбаруудад хийх; ирээдүйн эрсдэл, эмзэг байдлыг тодорхойлох; дүн шинжилгээ хийх 1.1 Судалгааны аргачлалыг захиалагч талаар баталгаажуулах 1.2 Нутгийн иргэдийн оролцоог хангах 1.3 Дээрх үнэлгээг хийхдээ Өмнөговь аймгийн холбогдох байгууллагуудад буй тайлан, судалгаа, шинжилгээний үр дүнг харгалзах, уялдуулах; техникийн мэргэжилтнүүдийг хамруулсан уулзалт хэлэлцүүлгээр баталгаажуулах 2. Өмнөговь аймгаас ялгарч буй хүлэмжийн хийн ялгаралтын (ХХЯ) хэмжээг эрчим хүч; аж үйлдвэр; хог хаягдал; зам тээвэр; барилга; хөдөө аж ахуй; газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлтөөс үүдэн гарах ХХЯ болон бусад салбар тус бүрээр тооцоолох; ирээдүйн ялгаралтын чиг хандлагыг олон улсад батлагдсан аргачлал, холбогдох үнэлгээ, төлөвлөлттэй уялдуулан тодорхойлох, дүн шинжилгээ хийх 2.1 Хүлэмжийн хийн ялгаралтын тооцооллын аргачлалыг захиалагч талаар баталгаажуулах 2.2 Эрчим хүчний салбараас ялгарах хүлэмжийн хийн ялгаралтыг эрчим хүчний үйлдвэрлэл, эрчим хүчний хэрэглээ гэж хуваан тооцох, 3. Өмнөговь аймгийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээг тодорхойлох, түүнийг Өмнөговь аймгийн дасан зохицох чадавхад тулгуурлан үнэлэх, эрэмбэлэх, дүн шинжилгээ хийх; 3.1 Дасан зохицох арга хэмжээг тодорхойлохдоо МУ-ын хөгжлийн бодлого, төлөвлөлт; үндэсний дасан зохицох төлөвлөгөө, аймгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт; мега төслүүдийн төлөвлөгөөг харгалзах, уялдуулах 3.2 Дасан зохицох арга хэмжээнд хувийн хэвшлийн оролцоог тодотгох, 3.3 Дасан зохицох арга хэмжээний хяналт, тайлагналт, баталгаажуулалтыг арга хэмжээ (салбар бүрээр) бүрд тодотгох 4. Өмнөговь аймгийн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах арга хэмжээг салбар тус бүрээр нь тодорхойлох, түүнийг Өмнөговь аймгийн сааруулах чадавхад тулгуурлан үнэлэх, эрэмбэлэх, дүн шинжилгээ хийх; 4.1 Сааруулах арга хэмжээг тодорхойлохдоо МУ-ын хөгжлийн бодлого, төлөвлөлт; аймгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт; мега төслүүдийн төлөвлөгөөг харгалзах, уялдуулах 4.2 Сааруулах арга хэмжээнд хувийн хэвшлийн оролцоог тодотгох, 4.3 Сааруулах арга хэмжээ тус бүрд хяналт, тайлагналт, баталгаажуулалтыг тодотгох 5. Өмнөговь аймгийн “Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хууль, эрх зүй, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хүрээнд боловсруулж, холбогдох төрийн болон төрийн өмчит байгууллага, судалгаа шинжилгээний байгууллагатай зөвшилцөн саналыг тусгах, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөртэй уялдах 6. Өмнөговь аймгийн “Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний төсөл,

		арга хэмжээг ШУ-ны үндэслэлтэйгээр боломжит байж болох үйл ажиллагааг тодорхойлон төлөвлөж, тус бүрийн өртөг, төсөв, санхүүгийн тооцооллыг хийх, эрэмбэлэх, дүн шинжилгээ хийх; 7. Өмнөговь аймгийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эрсдэл, эмзэг байдал, хүлэмжийн хийн ялгаралтын эх үүсвэр зэрэг уур амьсгалын өөрчлөлтийн талаарх газарзүйн мэдээллүүдийг агуулсан зургийг боловсруулах 8. Орон нутгийн болон салбарын экспертүүдээр хэлэлцүүлж санал авах, 9. Чиг үүргийн салбарын яамд, холбогдох байгууллагуудаас санал авах 10. Захиалагчийн хамт хөтөлбөр, төлөвлөгөөний төслийг холбогдох оролцогч талууд, орон нутгийн иргэдээр хэлэлцүүлэх, аймгийн ИТХ-аар танилцуулж, хэлэлцүүлэн батлуулах үйл явцад бэлтгэн хамтран оролцох.
6	Ашиглах материал:	- Засгийн газрын 2019 оны 407 дугаар тогтоол "Парисын хэлэлцээр", - Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн (ҮТХН) зорилт, ҮТХН зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө - Үндэсний дасан зохицох төлөвлөгөө Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны "Өсөлттэй Өмнөговь" хөтөлбөр болон бусад холбогдох бодлогын баримт бичиг, хөгжлийн төлөвлөлт - Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр - "Алсын хараа"-2050 - Шинэ сэргэлтийн бодлого - Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал
7	Хүлээн авах, ажил, үйлчилгээ:	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын тушаалаар батлагдсан ажил хүлээн авах комисст хүлээлгэн өгнө. - "Өмнөговь аймгийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сааруулах үйл ажиллагааны төлөвлөгөө" / санхүүгийн болон ажлын тайлан
8	Санхүүжилтийн эх үүсвэр:	Орон нутгийн төсвийн хөрөнгө: 80,000,000 төгрөг
9	Захиалагч байгууллага:	Аймгийн Засаг даргын Тамгын газар
10	Хүлээгдэж буй үр дүн:	Өмнөговь аймаг нь хүлэмжийн хийн ялгарал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, даван туулах чадвар бүхий аймаг болоход суурь мэдээлэл, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үйл ажиллагааны цар хүрээ, өртөг, өгөөжийн судалгаа бүхий биеэ даасан үйл ажиллагааны төлөвлөгөө бий болно.

ХЯНАСАН:
БҮС, ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ,
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ М.МӨНХМАА

БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН ДАРГА Х.ОТГОНМӨНХ

БОЛОВСРУУЛСАН:
БҮС, ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БОДЛОГО,
ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Д.НАРАНЧИМЭГ

БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН Б.Батжаргал Б.БАТЖАРГАЛ